



МОНГОЛ УЛСЫН  
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН  
САЙДЫН ТУШААЛ

2024 оны 04 сарын 22 өдөр

Дугаар 1832

Улаанбаатар хот

Ногоон хөгжлийн бодлогын хэрэгжилтийг  
эрчимжүүлэх үйл ажиллагааны  
төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6.5 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн хуралдааны 51 дүгээр тэмдэглэлийн 1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1."Алсын хараа 2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд Ногоон хөгжлийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралт ёсоор баталсугай.

2.Төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу боловсруулж, жил бүрийн 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор Засгийн газарт танилцуулж ажиллахыг Уур амьсгалын өөрчлөлт, бодлого, төлөвлөлтийн газар (Ш.Цэрэндулам), Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт тус тус үүрэг болгосугай.

3.Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахад салбар дундын зохицуулалт хийж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (С.Цогтгэрэл)-д даалгасугай.

Б.Ба



Б.БАТ-ЭРДЭНЭ

152400644

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын  
2024 оны дүгээр сарын 14-ны өдрийн  
108 дугаар тушаалын хавсралт

“АЛСЫН ХАРАА 2050” МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ  
ЭРЧИМЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ  
/2024-2028/

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга зам	Үйл ажиллагааны дугаар	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хэрэгжүүлэх хугацаа	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага	Хамтран хэрэгжүүлэгч байгууллага	Эх үүсвэр	Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт
<b>ЗОРИЛТ НЭГ: Байгалийн нөөцийн хэмнэлттэй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай үйлдвэрлэл, хэрэглээг хөгжүүлнэ.</b>								
1.1.	Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр, хэрэглээг нэмэгдүүлэх, эрчим хүчний хангамжийн үр ашгийг сайжруулах замаар эрчим хүчний салбарт ногдох хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах	1	Усан цэнэгт болон бага, дунд чадлын усан цахилгаан станцыг үе шаттайгаар хэрэгжүүлэх	2024-2028	ЭХЯ	БОАЖЯ, СаЯ, МУХАУТ, ЭХЗ	УТ, ОУБ, ХХ	Нийт 220 МВт-ын усан цэнэгт болон бага, дунд чадлын усан цахилгаан станц ашиглалтад орсон байна.
		2	Өрсөлдөөнт сонгон шалгаруулалтаар нар, салхины эх үүсвэрийг хэрэгжүүлэх	2024-2030	ЭХЯ		ХХ	Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийн тоо нэмэгдсэн байна.
		3	Цахилгаан дамжуулах сүлжээний алдагдлыг бууруулах	2024-2030	ЭХЯ	СаЯ	ОУБ	Төвийн бүсийн цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний үр ашгийг дээшлүүлсэн байна.
		4	Төвлөрсөн дулаан хангамжийн дулаан түгээлтийн алдагдлыг бууруулах	2024-2030	ЭХЯ	СаЯ	ОУБ	Улаанбаатар хотын дулаан хангамжийн магистрал шугамыг өргөтгөж шинэчилсэн байна.
		5	Дулааны цахилгаан станцуудын дотоод хэрэгцээний цахилгааны хэрэглээг бууруулах	2024-2030	ЭХЯ		УТ, ОУБ	Түүхий нүүрсний хэрэглээг үе шаттай хязгаарлана.
		6	Аймгийн төвүүдийн дулаан хангамжийг сайжруулах	2024-2030	ЭХЯ	СаЯ, АЗД, МУХАУТ	УТ, ОУБ	10 аймгийн төв дулааны станц, дулааны шугам сүлжээ, дулаан түгээх төв байгуулсан байна.
		7	Орон нутгийн дулаан хангамжид газрын гүний дулаан ашиглах	2024-2030	ЭХЯ	СаЯ	8	"Сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх төсөл"-ийн хүрээнд 5 байршил нийт 0.5 МВт-ын хүчин чадал бүхий хөрсний дулааны насосын системийг суурилуулна.

	8	Төв суурин газрын түүхий нүүрсээр ажилладаг усан халаалтын зууханд техник технологийн шинэчлэл хийх	2024-2030	АНЗД	ЭМЯ БШУЯ ХЗДХЯ БХБЯ	УТ, ОУБ	Түүхий нүүрсний хэрэглээг үе шаттай хязгаарлана.
	9	Өрхийн түвшинд сэргээгдэх эрчим хүчний шилжилт хийх төслийг өргөжүүлж, хамрагдах гэр хорооллын айл өрхийн тоог нэмэгдүүлэх	2024-2030	Орхон ЗДТГ	БОАЖЯ	УТ, ОУБ	Гэр хорооллын өрхийг сэргээгдэх эрчим хүчний хэрэглээнд шилжүүлж, агаар бохирдуулах эх үүсвэрийн тоо буурсан байна.
1.2.	1	Ногоон барилгын үйлдвэрлэл, хэрэглээг нэмэгдүүлэх, тэдгээрийг дэмжин урамшуулах механизм	2024-2028	БХБЯ, АНЗД	Сая, ЭЗХЯ, БОАЖЯ	УТ, ОНТ, ОУБ	Орон сууцны дулаан алдагдлыг 30-40 хувиар бууруулсан байна.
	2	Ногоон барилгын төлөвлөлт, зураг төсөл, барилга угсралтын чиглэлээр барилгын салбарын хүний нөөцийг чадавхжуулах ажлыг зохион байгуулах	2024-2028	БХБЯ	МНБХ, Салбарын ТББ-ууд	ОУБ	Хүний нөөцийг чадавхжуулсан байна.
	3	Эрчим хүчний хэмнэлттэй, дулаан алдагдалгүй, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр бүхий пассив хувийн болон нийтийн орон сууцны ногоон зээлд хамруулах нөхцөлийг бүрдүүлэх	2024-2028	БХБЯ, ЭХЯ	Сая, БОАЖЯ	УТ, ОУБ, ХХ	Пассив хувийн болон нийтийн орон сууцны хэрэглээг нэмэгдүүлсэн байна.
	4	Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр барих, засварлах барилгуудад ногоон барилгын стандарт нэвтрүүлж, ногоон барилгын зэрэглэл тогтоож гэрчилгээжүүлэх ажлыг зохион байгуулах	2024-2028	БХБЯ	МНБХ, Бусад холбогдох яамд	УТ, ОНТ, ОУБ	Ногоон барилгын технологи хөгжүүлэх, дамжуулах, судлах, турших, нэвтрүүлэх арга ажиллагааг хөгжүүлсэн байна.
1.3.	1	Өрсөлдөөнийг урамшуулж бүтээмжийг дээшлүүлэхийн зэрэгцээ байгаль орчны чадавхын хэм хэмжээ, стандартыг олон улсын жишигт нийцүүлэн тогтоож мөрдүүлэх, байгаль нөлөөлөх байдлын үнэлгээний үр дүнг сайжруулах	2024-2028	БОАЖЯ	СХЗГ	ОУБ, УТ	Олон улсын жишигт нийцүүлсэн стандартыг тогтоож, мөрдүүлсэн байна.
	2	Дэвшилтэт технологи нутагшуулах, шинэ технологи бий болгох судалгаа, хөгжлийг урамшуулж, дэмжих эрх зүйн зохицуулалт бүрдүүлж, хэрэгжүүлэх	2024-2028	ХХААХУЯ,	БОАЖЯ БШУЯ	ОУБ, УТ	Технологийн судалгаа, хөгжлийг дэмжих эрх зүйн зохицуулалт бүрдсэн байна.
	3	Байгаль орчинд ээлтэй дэвшилтэт арга, технологийг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлсэн "Эко тэмдэг", "Ногоон гэрчилгээ" бүхий иргэн, аж ахуйн нэгжийн тоог нэмэгдүүлэх, урамшууллын хөшүүргийг нэвтрүүлэх	2024-2028	БОАЖЯ	Тос	ОУБ, УТ	"Эко тэмдэг", "Ногоон гэрчилгээ"-тэй байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, 100-аас доошгүй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад "Ногоон гэрчилгээ" олгосон байна.
	4	Үйлдвэрлэлийн салбарууд технологийн үнэлгээ, судалгаа хийх тогтолцоо бий болгож, чадавхыг бүрдүүлэх	2024-2028	БШУЯ, ЭХЯ, УУХУЯ, ХХААХУЯ, БХБЯ	БОАЖЯ, ЗТХЯ	ОУБ, УТ	Үйлдвэрлэл технологийн судалгааны тогтолцоо, чадавх бий болж, үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл буурсан байна.

1.4.	Хөдөө аж ахуйн тогтвортой хөгжлийг дэмжиж, ногоон технологид суурилсан экспортын баримжаатай боловсруулах үйлдвэрлэлийн кластерыг хөгжүүлж, арьс шир, ноос, ноолуур зэрэг түүхий эдийн бүрэн боловсруулалтыг 80 хувьд хүргэх	5	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгэр дамжуулан байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт ногоон технологийг нэвтрүүлж, байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийн үр дүнг сайжруулж, холбогдох мэдээллийг ухаалаг системд холбох	2024-2028	БОАЖЯ	ААНБ	УТ, ХХ	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгэр дамжуулан байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт ногоон технологийг нэвтрүүлж байгаль орчныг хамгаалах хуулийн хэрэгжилт сайжирсан байна.
6	Засгийн газраас хэрэгжүүлэх хөнгөлөлттэй зээл, санхүүжилтийг "Тогтвортой хөгжлийн зорилтын санхүүжилтийн таксономи"-ийн суурь босго, шалгуур үзүүлэлттэй уялдуулж хэвшүүлэх	6	Засгийн газраас хэрэгжүүлэх хөнгөлөлттэй зээл, санхүүжилтийг "Тогтвортой хөгжлийн зорилтын санхүүжилтийн таксономи"-ийн суурь босго, шалгуур үзүүлэлттэй уялдуулж хэвшүүлэх	2024-2028	СаЯ	ЭЗХЯ, БОАЖЯ, ТоС холбоо	ОУБ	"Тогтвортой хөгжлийн зорилтын санхүүжилтийн таксономи"-ийг хэрэгжүүлж хэвшсэн байна.
1	Арьс шир, ноос, ноолууран түүхий эдийн боловсруулалтын түвшин, чанарыг сайжруулж, инновацид тулгуурласан ногоон технологи бүхий бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөгжүүлж, экспортыг нэмэгдүүлэх	1	Арьс шир, ноос, ноолууран түүхий эдийн боловсруулалтын түвшин, чанарыг сайжруулж, инновацид тулгуурласан ногоон технологи бүхий бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөгжүүлж, экспортыг нэмэгдүүлэх	2024-2028	ХХААХУЯ	ХХААХУЯ, БОАЖЯ АНЗД	ХХ, УТ, ОНТ	Хаягдлын хэмжээ буурч, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспорт нэмэгдэнэ. ХАА-н гаралтай түүхий эдийн бүрэн боловсруулалтыг 80 хувьд хүргэсэн байна.
2	Ойн хаягдал, биомассын ашиглалтыг нэмэгдүүлж, шахмал түлш, шахмал хавтангийн боловсруулах үйлдвэрлэлийн үйл ажиллагааг өргөжүүлэх	2	Ойн хаягдал, биомассын ашиглалтыг нэмэгдүүлж, шахмал түлш, шахмал хавтангийн боловсруулах үйлдвэрлэлийн үйл ажиллагааг өргөжүүлэх	2024-2028	ХХААХУЯ	БОАЖЯ БХБЯ, АНЗД	ХХ	Хэрэглээний зориулалтаар бэлтгэсэн модыг хаягдалгүй ашигладаг болсон байна.
3	Газар тариалангийн үйлдвэрлэлд цомхоттосон болон тэг элдэншүүлэг бүхий дэвшилтэд технологийг үе шаттайгаар нэвтрүүлж, тариалангийн талбайн ашиглалтын цахим мэдээллийн сан байгуулах	3	Газар тариалангийн үйлдвэрлэлд цомхоттосон болон тэг элдэншүүлэг бүхий дэвшилтэд технологийг үе шаттайгаар нэвтрүүлж, тариалангийн талбайн ашиглалтын цахим мэдээллийн сан байгуулах	2024-2028	ХХААХУЯ	БОАЖЯ, ГЗБГЗЗЭГ Бүх шатны ЗД	ХХ, УТ	Цомхоттосон болон тэг технологиор боловсруулсан талбайн хэмжээ 2024 онд нийт тариалсан талбайн 80-аас дээш хувьд хүрнэ. Мэдээллийн цахим сан бий болгосон байна.
1.5.	Байгаль орчин, эрүүл ахуйн шаардлага хангасан эко аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх	1	Тусгай хамгаалалттай газар нутаг ЛХГН/-т байрлах аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагын тоо, хүчин чадал, үйлчилгээний төрлийг тухайн газрын нөөц, даацад тулгуурлан тогтоож хэрэгжүүлэх	2024-2028	БОАЖЯ	АНЗД	ОУБ	Байгалийн даац чадаахад нийцсэн аж ахуй эрхлэх болсны дүнд экосистемийн тогтвортой байдал хадгалагдана.
2	Байгаль орчинд ээлтэй эко аялал жуулчлалын шаардлага, шалгуур үзүүлэлтийг боловсруулах, эко аялал жуулчлалын жишиг бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлж ЛХГН-т түгээн дэлгэрүүлэх	2	Байгаль орчинд ээлтэй эко аялал жуулчлалын шаардлага, шалгуур үзүүлэлтийг боловсруулах, эко аялал жуулчлалын жишиг бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлж ЛХГН-т түгээн дэлгэрүүлэх	2024-2028	БОАЖЯ	АНЗД	ОУБ, ХХ	Эко аялал жуулчлалын шалгуур үзүүлэлт гарч, эко аялал жуулчлал төлөвшиж, иргэд, хувийн хэвшлийн орлого нэмэгдсэн байна.
3	Аялал жуулчлалын үйлчилгээ, түүний дэд бүтцийн байгууламжийн стандартыг ногоон зарчимд нийцүүлэн шинэчлэн боловсруулж мөрдүүлэх	3	Аялал жуулчлалын үйлчилгээ, түүний дэд бүтцийн байгууламжийн стандартыг ногоон зарчимд нийцүүлэн шинэчлэн боловсруулж мөрдүүлэх	2024-2028	БОАЖЯ	СХЗГ	УТ	Аялал жуулчлалын салбараас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөө буурсан байна.
1.6	Байгальд орчинд ээлтэй, хүний эрүүл мэнд болон биологийн олон янз байдалд сөрөг	1	Улсын хэмжээнд хийсэн экосистемийн бүсчлэлийн үнэлгээнд тулгуурлан байгаль, соёлын өвийн хувьд чухал ач холбогдолтой газруудад ашигт малтмалын эрэл хайгуул, олборлолтыг хязгаарлах	2024-2028	БОАЖЯ, ГХГЗЗГ	УУХУЯ, ШУА	ОУБ	Улсын хэмжээнд байгаль, соёлын өвийн чухал ач холбогдолтой газрууд тодорхой болж, хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.

	нөлөөгүй үйлдвэрлэл, бүтэц, тээврийн сүлжээ, байгаль орчинд нөлөө багатай үйлдвэрлэлийг хөгжүүлэх	2	Төмөр зам, авто замын дагуу нүүдлийн зэрлэг амьтдад зориулсан гарц, гарам байгуулах стандартыг мөрдүүлэх	2024-2028	БОАЖЯ	ЗТХЯ, СХЗГ	ОУБ	Стандартын хангуулсан байна.	
		3	Уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэлтийн байгаль орчинд сөрөг нөлөө багатай, үр ашигтай байх шийдлийг судлан нэвтрүүлэх	2024-2028	ЗТХЯ	УУХУЯ, БОАЖЯ	ОУБ, ХХ	Уул уурхайн бүтээгдэхүүний тээвэрлэлтэд байгаль орчинд сөрөг нөлөө багатай шийдэл нэвтрэгсэн байна.	
		4	Орчны бохирдлыг бууруулах, нөөцийн үр ашгийг нэмэгдүүлэх техник технологийг сурталчлан таниулах зорилготой "Ногоон технологи" үзэсгэлэн, семинарыг жил бүр зохион байгуулах	2024-2028	БОАЖЯ	Бусад холбогдох яамд, МҮХАҮТ, байгуул-лагууд	УТ, ОУБ, ХХ	Үзэсгэлэн, семинарыг тогтмол зохион байгуулж, орчны бохирдлыг бууруулах, нөөцийн үр ашгийг нэмэгдүүлэх, байгаль ээлтэй техник технологийг иргэд, олон нийтэд сурталчлан таниулж, дэлгэрүүлсэн байна.	
<b>ЗОРИЛТ ХОЁР: Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлэн орчны бохирдол, доройтлыг бууруулж, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгална.</b>									
2.1.	Байгалийн унаган терх, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах, цэнгэг усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх эхийн 60-аас доошгүй хувийг тусгай хамгаалалтад авах	1	Тусгай хамгаалалттай газар нутаг ТХГН-ийн тогтвортой санхүүжилтийн механизмыг нэвтрүүлэх, хамгаалалтын менежментийг сайжруулахад чиглэсэн эрх зүйн орчныг боловсронгуй болгох	2025-2026	БОАЖЯ	ГЗБГЗЗЕГ	УТ, ОУБ	Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсан байна.	
		2	Цэнгэг усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх эхийн 60-аас доошгүй хувийг тусгай хамгаалалтад авах	2024-2028	БОАЖЯ	УГ	УТ, ОУБ	Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг 25-аас доошгүй хувьд хүрсэн байна.	
		3	Хил дамнасан ТХГН, шим мандлын дархан газрын хамтын ажиллагааг өргөжүүлж, хяналт, судалгаа шинжилгээний ажлыг хамтран зохион байгуулж, хамгаалалтын менежментийг бэхжүүлэх	2024-2028	БОАЖЯ	ГХЯ, ХХЕГ	ОУБ	Хил дамнасан ТХГН-ийн менежмент сайжирсан байна.	
		4	Хангай нуруу, түүний салбар уулс, Хөвсгөл нуур орчмын ТХГН-ыг түшиглэн байгалийн нөөц, соёлын өвийн дурсгалт нутаг болгон хөгжүүлж, уул уурхайн үйлдвэрлэлийг хязгаарлаж, ногоон хөгжлийн жишиг нутаг болгох	2024-2030	БОАЖЯ	АНЗД	ОУБ, УТ	Байгалийн нөөцийн үндэсний парк бий болж, ногоон хөгжлийн жишиг нутаг болсон байна.	
		5	Хан Хэнтийн дархан цаазат газар, тэдгээрийн орчны бүсийг байгалийн нөөцийн үндэсний парк, байгаль, соёлын өвийн дурсгалт газар нутаг болгон хөгжүүлж, экосистемийн үйлчилгээг тогтвортой хадгалах	2024-2030	БОАЖЯ	ЭЗХЯ, АНЗД	ОУБ, УТ	Байгалийн нөөцийн үндэсний парк, соёлын өвийн дурсгалт газар бий болж, ногоон хөгжлийн жишиг нутаг болсон байна.	
2.2.	Уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөг сааруулах, дасан зохицох	1	Уур амьсгалын ногоон сан, Дасан зохицлын сан, Нүүрстөрөгчийн сан зэрэг олон улсын сангаас санхүүжилт, дэмжлэг авах зорилгоор төсөл боловсруулах, төсөл хэрэгжүүлэх чиглэлээр менежментийн чадавх бүрдүүлэх	2024-2028	БОАЖЯ	Сая	ОУБ, БХС	Сангуудтай шууд харьцаж, санхүүжилт татах чадавх бүрдэж, Үндэсний хэрэгжүүлэгч нэгжтэй болсон байна.	

2.3.	Үндэсний чадавхыг бэхжүүлэх	2	Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төлөвлөгөөг эдийн засаг, нийгмийн голлох салбар болон бусад асуудлыг тусган баталж хэрэгжилтийг хангах	2024-2028	БОАЖЯ	Сая, ЭЗХЯ, ХХААХҮЯ, ЭХЯ, бусад яамд	ОУБ	Дасан зохицох төлөвлөгөөг хэрэгжүүлж, эрсдэлээс урьдчилсан сэргийлэх, эмзэг байдлыг бууруулах чиглэлээр чадавх нэмэгдсэн байна.
		3	Уур амьсгалын өөрчлөлтөд нэн эмзэг бүс нутгийн дасан зохицох чадавхыг нэмэгдүүлэх жишиг төслүүдийг хэрэгжүүлэх	2024-2028	БОАЖЯ	АНЗД	ОУБ	2-3 бүс нутагт төсөл хэрэгжиж, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, эрсдэлийг даван туулах чадавх нэмэгдсэн байна.
		4	Байгаль, цаг агаарын аюулт үзэгдлийг урьдчилан мэдээлэх, сэрэмжлүүлэх чадавхыг бэхжүүлж, таваас доошгүй байршилд радарын станц байгуулах	2024-2028	БОАЖЯ ЦУОШГ	АНЗД	УТ, ОУБ	Улсын хэмжээнд радарын сүлжээ бий болж, байгаль, цаг агаарын аюулт үзэгдлийг урьдчилан мэдээлэх, сэрэмжлүүлэх чадавх бүрдсэн байна.
2.4.	Биологийн олон байдлын санг хамгаалах, тархац нутаг, амьдрах орчныг тэтгэх замаар хомсдолоос сэргийлж, ашиглалтын нөөц бүрдүүлэх	1	Монгол орны амьтан, ургамал, бичил биетний ангилал зүйн бүртгэлийн мэдээллийн сан бүрдүүлэх	2024-2028	БОАЖЯ	ШУА	УТ, ОУБ	Нийт 9 чиглэлээр ангилал зүйн тайлан гарч мэдээллийн сан бүрдсэн байна.
		2	Харь зүйлийн эрсдэлийн үнэлгээ, хяналтын механизмыг бүрдүүлэх	2024-2028	БОАЖЯ	ХХААХҮЯ	УТ, ОУБ	Харь зүйлээс экосистемд учруулж болох эрсдэлээс сэргийлэх механизм бүрдсэн байна.
		3	Эдийн засгийн эргэлтэд оруулж болох бүтээгдэхүүн гаргах загвар төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагааг дэмжих	2025-2028	БОАЖЯ БШУЯ	ХХААХҮЯ	ОУБ, УТ, ХХ	Генетик нөөц, уламжлалт мэдлэг ашиглан экспортын болон ашиг хүртэх шинэ бүтээгдэхүүнийг бий болгосон байна.
2.4.	Ойжуулах ажлыг эрчимжүүлж, ойгоор бүрхэгдсэн талбайг нийт газар нутгийн 9.0 хувьд хүргэж, нүүрсхүчлийн хийн шингээлтийг нэмэгдүүлэх	1	"Тэрбум мод" хөдөлгөөний хүрээнд стандартын шаардлага хангасан үр, тарьц, суулгацын нөөцийг нэмэгдүүлж, ойжуулалт, ойг нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлэх	2024-2028	БОАЖЯ	АНЗД	УТ, ОНТ, ОУБ	Үр, тарьц, суулгацын нөөцийг нэмэгдүүлж, доройтсон ойг нөхөн сэргээх, ойжуулалтыг нэмэгдүүлж, байгалийн сэргэн ургалтыг дэмжиж, ойн сан бүхий газрыг нийт газар нутгийн 9.0 хувьд хүргэсэн байна.
		2	"Тэрбум мод сан"-ийн үйл ажиллагааг бодлогоор дэмжиж, байгаль хамгаалал, уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг зорилт, арга хэмжээтэй уялдуулах	2024-2028	Монголын Банкны Холбоо	Тос Холбоо БОАЖЯ	ХХ	"Тэрбум мод сан"-ийн үйл ажиллагааны хүрээ өргөжиж, улсын хөгжлийн бодлого, төлөвлөлттэй уялдсан байна.
		3	Ойг түймэр, хөнөөлт шавж, өвчнөөс хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх	2024-2028	БОАЖЯ	АНЗД	УТ, ОНТ, ОУБ	Түймрээс хамгаалах зурвасыг сэргээж, хөнөөлт шавжийн тархалт тогтоох судалгаа, тэмцлийн ажил хэрэгжүүлсэн байна.

2.6.	Хур бороо, цас, үерийн усыг хуримтлуулан ашиглах санаачилга, гадаргын усны хуримтлал бий болгон ашиглах газрын төсөл, доорх усыг нөхөн сэргээх, нөөцийг нэмэгдүүлэх туршилт судалгааг хөхиүлэн дэмжих	4	Ой зохион байгуулалтыг тогтмол зохион байгуулж, ойд арчилгаа, цэвэрлэгээний арга хэмжээг хэрэгжүүлэх	2024-2028	БОАЖЯ	АНЗД	УТ, ОНТ, ОУБ	Ой зохион байгуулалтын судалгааны ажлыг жил бүр 2 сая га талбайд, ойн арчилгааны ажлыг 30 мянган га талбайд хийж ойн төлөв байдлыг сайжруулсан байна.
2.7.	Эдийн засгийн хурдацтай өсөлт, уур амьсгалын өөрчлөлтийн нөхцөлд хүний үйл ажиллагаанаас байгаль орчинд учруулах хор уршгийг багасгах, арилгах нөхцөлийг бүрдүүлж хуурайшил, газрын доройтол, цөлжилтийн сөрөг үр дагаврыг бууруулах	5	Ойн тооллогын үр дүнд суурилсан нүүрсхүчлийн хийн шингээлтийг олон улсад зөвшөөрөгдсөн нийтлэг арга зүйгээр тодорхойлох, хүлэмжийн хийн худалдааг өргөтгөх ажлыг зохион байгуулах	2024-2028	БОАЖЯ	АНЗД	УТ, ОУБ	Ойн нүүрсхүчлийн хийн шингээлтийг тооцоолох чадавхыг бүрдүүлж, хүлэмжийн шингээлтийг суурь үзүүлэлтийг тодорхойлж, нүүрсгөрөгчийн арилжаа хийх боломж бүрдсэн байна.
1	Хур бороо, цас, мөсний усны нөөцийг хуримтлуулах хөв, усан сан байгуулах	1	Хур бороо, цас, мөсний усны нөөцийг хуримтлуулах хөв, усан сан байгуулах	2024-2028	БОАЖЯ	АНЗД	УТ, ОНТ, ХХ	Усны нөөцийн эх үүсвэрүүд бий болж, усны хангамж сайжирсан байна.
2	Усыг хуримтлуулж нөөцийг нэмэгдүүлэх, газрын доорх усны ордыг зориудаар цэнэглэж арвижуулах, нөхөн сэргээх туршилт судалгаа явуулах	2	Усыг хуримтлуулж нөөцийг нэмэгдүүлэх, газрын доорх усны ордыг зориудаар цэнэглэж арвижуулах, нөхөн сэргээх туршилт судалгаа явуулах	2024-2028	БОАЖЯ	ШУА	УТ	Усыг нөөцлөх жишиг төслүүд хэрэгжсэн байна.
3	Цас, борооны усыг нөөцлөх, хөрсөнд шингээх технологийг ус хангамж, хөдөө аж ахуй, газар тариалан зэрэг салбаруудад нэвтрүүлэх	3	Цас, борооны усыг нөөцлөх, хөрсөнд шингээх технологийг ус хангамж, хөдөө аж ахуй, газар тариалан зэрэг салбаруудад нэвтрүүлэх	2024-2028	БОАЖЯ	ХХААХУЯ, АНЗД	УТ, ОНТ	Газрын доорх усны нөөцийн нөхөн сэлбэгдлийн хувь дээшилсэн байна.
4	Барилга байгууламжийн дээврийн хур борооны усыг цуглуулах технологийн шийдлийг дэмжиж, айл өрх, ААНБ-ын ахуйн хэрэгцээ, ногоон байгууламжийн усалгааны хэрэгцээг хэвшүүлэх	4	Барилга байгууламжийн дээврийн хур борооны усыг цуглуулах технологийн шийдлийг дэмжиж, айл өрх, ААНБ-ын ахуйн хэрэгцээ, ногоон байгууламжийн усалгааны хэрэгцээг хэвшүүлэх	2024-2028	БХБЯ	БОАЖЯ АНЗД, ИТХ	УТ, ХХ	Хур борооны усыг цуглуулж, ашигладаг өрх, ААНБ-ын тоо нэмэгдсэн байна.
1	Говийн баян бүрдийг хамгаалах, нөхөн сэргээх төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх	1	Говийн баян бүрдийг хамгаалах, нөхөн сэргээх төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх	2024-2028	АЗДТГ	БОАЖЯ	УТ, ОНТ, ХХ	Говийн аймгууд 10-аас доошгүй баян бүрдийг хамгаалалтад авсан байна.
2	Бэлчээрийн менежментийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох	2	Бэлчээрийн менежментийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох	2024-2026	ХХААХУЯ	БОАЖЯ, ГЗБГЗЗЕГ	УТ	Холбогдох эрх зүйн орчин бүрдсэн байна.
3	Бэлчээрийн даац, нөхөн сэргээх чадавхад тохирсон малын тоо, бүтцийг төрөл тус бүрээр бүсчлэн тогтоож, даацад тохирсон тогтвортой аж ахуй эрхлэх механизмыг татварын, эдийн засгийн болон санхүүжилтийн хөшүүрэг ашиглан бүрдүүлэх	3	Бэлчээрийн даац, нөхөн сэргээх чадавхад тохирсон малын тоо, бүтцийг төрөл тус бүрээр бүсчлэн тогтоож, даацад тохирсон тогтвортой аж ахуй эрхлэх механизмыг татварын, эдийн засгийн болон санхүүжилтийн хөшүүрэг ашиглан бүрдүүлэх	2025-2026	ХХААХУЯ	БОАЖЯ, Бүх шатны ЗД	УТ, ОНТ, ХХ, ОУБ	Бүх сумдад бэлчээрийн даацад тохирсон мал аж ахуйн зохистой менежментийг бүрдүүлсэн байна. Татвар, эдийн засгийн хөшүүргийг ашиглах боломж бүрдсэн байна.
4	Газрын чанарын төлөв байдлын Хяналт-шинжилгээний сүлжээг боловсронгуй болгох	4	Газрын чанарын төлөв байдлын Хяналт-шинжилгээний сүлжээг боловсронгуй болгох	2024-2028	БОАЖЯ	АНЗД, ГЗБГЗЗЕГ	УТ, ОУБ	Газрын доройтол, цөлжилтийн Хяналт-шинжилгээ, мэдээллийн цогц сүлжээ бүрдсэн байна.
5	Бэлчээрийн газрын үнэ цэнийг тогтоох, газар ашиглалт, мал аж ахуйн салбараас ялгарах хүлэмжийн хийн тооллого явуулах арга зүйг нэвтрүүлж тооцоолох	5	Бэлчээрийн газрын үнэ цэнийг тогтоох, газар ашиглалт, мал аж ахуйн салбараас ялгарах хүлэмжийн хийн тооллого явуулах арга зүйг нэвтрүүлж тооцоолох	2024-2028	БОАЖЯ	ХХААХУЯ, ОУБ	ОУБ	Байгалийн эдийн засгийн үнэ цэнэ, өгөөжийг тогтоох систем бүрдэж, мал аж ахуйгаас үүсэх байгальд учруулах нөлөөллийн судалгаа, тоон мэдээлэл бүрдсэн байна.

2.8.	Үйлдвэрлэлийн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон, бохирдолд өртсөн, атаршсан газрын 70-аас доошгүй хувийг нөхөн сэргээж аж ахуйн зориулалтаар дахин ашиглахад чиглэсэн үйл ажиллагааг дэмжих	1	Ашигт малтмалын төрөл, олборлох, боловсруулах технологийн онцлогийг тусгасан байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх Европын холбооны болон бусад орны стандартыг нутагшуулж мөрдүүлэх	2024-2028	БОАЖЯ	СХЗГ	ОУБ	Стандарт батлагдаж мөрдөгдсөн байна.
		2	Уурхайн хаалт, нөхөн сэргээлт хийгдээгүйгээс болон хууль бусаар ашигт малтмал олборлосны улмаас байгаль орчинд учирсан хохирлыг тооцох аргачлал, жишиг үнэлгээг нарийвчлан боловсруулж, хохирлыг нөхөн төлүүлэх, нөхөн сэргээх боломжийг бүрдүүлэх	2024-2028	БОАЖЯ	УУХҮЯ	ОУБ	Аргачлал боловсруулж, 2-оос доошгүй газарт байгаль орчны хохирлыг тооцож, туршсан байна.
		3	Ашиглалтын нөөц нь эдийн засгийн үр ашиг багатай, байгаль орчинд сөрөг нөлөө ихтэй алтны шороон болон үндсэн орд, жоншны ордуудад ашиглалтын тусгай зөвшөөрөл олгохгүй байх, нөөцийн хаягдал их гаргадаг техник, технологийг уул уурхайн үйлдвэрлэлд нэвтрүүлэхгүй байх эрх зүйн болон зохион байгуулалтын арга хэмжээ авах	2024-2028	УУХҮЯ	БОАЖЯ	УТ	Ашиглалтын нөөц багатай алтны шороон болон үндсэн орд, жоншны ордод тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг зогсоосон байна.
2.9	Орчны бохирдлын хяналт шинжилгээний сулжээг өргөжүүлж, судалгааны ажлыг тогтмол хийж, байгальд ээлтэй, үр ашигтай, дэвшилтэт технологи нэвтрүүлж, нүхэн жорлонгоос үүдэлтэй хөрсний бохирдлыг 30 хувиар бууруулах	1	Улаанбаатар хот орчмын хүнд металл, өвчин үүсгэгч нянгаар бохирдсон хөрсийг физикийн болон биологийн аргаар цэвэршүүлэх, шаардлагатай тохиолдолд бохирдсон хөрсийг хуулж устгах арга хэмжээг хэрэгжүүлэх	2025	НБОГ НЗД	НЭМҮТ	УТ	Хөрсний бохирдол буурсан байна.
		2	Улсын хэмжээнд хөрсний бохирдлын иж бүрэн судалгаа хийх байнгын мониторингийн цэгийг нэмж байгуулах	2025-2026	БОАЖЯ	ЭМЯ	УТ	Мониторингийн цэгийн тоо нэмэгдсэн байна.
		3	Хот, суурин газрын гэр хорооллын айлуудад хөрсөнд нэвчдэггүй эко жорлон суурилуулах шаардлага тавьж, бохир усыг соруулах зориулалт бүхий бохирын нэгдсэн хураагуртай болгох	2026-2029	АНЗД, НБОГ	-	УТ	Нэгдсэн систем суурилуулсан байна.
		4	Хөрсний чанарын MNS 5850:2019, хөрсний эрүүл ахуйн аюулгүйн үзүүлэлт, бохирдлыг үнэлэх MNS 3297:2019 стандартын дагуу нянгийн бохирдлын шинжилгээг бүрэн хийх зорилгоор Байгаль орчны хэмжил зүйн төв лабораторийн тоног төхөөрөмжийг шинэчилж, сайжруулах	2025-2026	БОАЖЯ	ЦУОШГ	УТ	Тоног төхөөрөмжийг шинэчилж, бохирдлын эрсдэлийг тухай бүр тодорхойлсон байна.
		5	Хөрсний бохирдлын түвшнийг тогтоож, хүний эрүүл мэндэд нөлөөлөх нөлөөллийн судалгааг хийж, урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг арилгах арга хэмжээг хэрэгжүүлэх	2025-2026	БОАЖЯ	НЭМҮТ	УТ	Хөрсний бохирдлын түвшнийг тогтоож, хөрсний бохирдлоос хүний эрүүл мэндэд нөлөөлөх нөлөөллийг арилгах арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.
		6	Нүхэн жорлон, угаадасны MNS 5924:2015 стандартыг шинэчлэн боловсруулж, батлуулах	2024-2025	БХБЯ	БОАЖЯ, СХЗГ	УТ	Стандартыг шинэчилж, батлуулсан байна.

2.10	Агаар, орчныг бохирдуулагч эх үүсвэрийг багасган, агаарын бохирдлоос хүний эрүүл мэндийг хамгаалж, агаар, орчны бохирдлыг 80 хувиар бууруулах	7	Улаанбаатар хот болон бусад томоохон хот суурин газрууд, үйлдвэр уурхайн газруудад стандартын шаардлага хангаагүй нүхэн жорлон шинээр нэмэхийг хориглох, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны А/615 дугаар тушаалаар батлагдсан "Улаанбаатар хотын хөрсний чанарыг сайжруулах бүс тогтоож, дагаж мөрдөх журам"-ын дагуу бүс тогтоож, нүхэн жорлонг үе шаттай бууруулах	2025-2028	НБОГ	БОАЖЯ	УТ	Улаанбаатар хотын хөрсний чанарыг сайжруулах бүс тогтоож, хангаагүй нүхэн жорлогийн тоог бууруулсан байна.
		8	Хөрс бохирдуулагч аж ахуйн нэгж, иргэний бүртгэлийг улсын хэмжээнд гаргах, нэгдсэн мэдээллийн сан бий болгох	2024-2025	БОАЖЯ	ЦУОШГ	УТ	Мэдээллийн санг шинэчилсэн байна.
		1	Агаар бохирдуулах эх үүсвэрийн төрөл, эзлэх хувь хэмжээг шинэчлэн тогтоох	2024-2025	БОАЖЯ	ЦУОШГ	УТ	Агаар бохирдуулах эх үүсвэрийн төрөл, эзлэх хувь хэмжээг шинэчлэн тогтоож, байнгын хяналтыг хэрэгжүүлж, эх үүсвэрийн тоог бууруулсан байна.
		2	MNS 4585-2016 Агаарын чанар, техникийн ерөнхий шаардлага, стандартыг шинэчлэн боловсруулж батлуулах, хэрэгжүүлэх	2024-2028	БОАЖЯ, ЭМЯ	ЦУОШГ, СХЗГ	УТ, ОУБ	Агаарын чанарын стандарт, техникийн ерөнхий шаардлагыг шинэчлэн боловсруулж батлуулан, хэрэгжүүлж эхэлсэн байна.
		3	Асфальтобетон, хуванцар, яс боловсруулах, хаягдал түүхий эд боловсруулах үйлдвэр зэрэг агаар, орчин бохирдуулах бусад эх үүсвэрүүдэд байнгын хяналт тавьж, нэгдсэн стандарт мөрдүүлэх	2024-2025	БОАЖЯ	УУХУЯ, ХХААХУЯ	УТ	Агаар бохирдуулах бусад эх үүсвэрүүдэд хяналт сайжирч, экологийн нэгдсэн стандарт тогтоож, мөрдүүлсэн байна.
		4	Цахилгаан тэжээлт авто тээврийн хэрэгслийг цэнэглэх зориулалттай бүх төрлийн цэнэглэгчийг онцгой албан татвар, гааль нэмэгдсэн өртгийн албан татвараас хөнгөлж, чөлөөлөх	2025-2026	СаЯ	БОАЖЯ, ЭХЯ, ЗТХЯ	УТ	Цахилгаан тэжээлт авто тээврийн хэрэгслийн тоо нэмэгдэж, автомашинаас ялгарах бохирдол буурсан байна.
		1	Хог тээврийн байгууллагуудыг хувийн хэвшилд шилжүүлэх	2024-2026	АНЗД	БОАЖЯ	УТ	Хог тээврийн байгууллагуудыг хувийн хэвшилд шилжүүлсэн байна.
		2	Айл өрхийн хэрэглээнээс үүсэх энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийг нэг иргэнээр тогтоох хуулийн хэрэгжилтийг хангуулах	2024-2026	АНЗД	БОАЖЯ	УТ	Хуулийн хэрэгжилт хангагдсан байна.
		3	Цахилгаан хэрэгслээс үүсэх хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин боловсруулах, устгах, экспортлох эрх зүйн орчныг сайжруулах	2025-2027	ЦХХХЯ	БОАЖЯ, АНЗД	УТ	Эрх зүйн акт шинэчлэгдсэн байна.
		4	Аймгийн төв болон бүсийн төвүүдэд дахивар бэлтгэн нийлүүлэх зориулалттай хог хаягдал ангилан ялгах бүрэн автоматажсан төв байгуулах	2026-2030	АНЗД	БОАЖЯ,	УТ	Хог хаягдал ангилан ялгах бүрэн автоматажсан төв байгуулсан байна.
2.11.	Үр ашигтай, хэмнэлттэй технологийг дэмжих, хүн амд амьдрах орчны эрүүл ахуйн мэдлэг, зөв дадлыг олгох замаар хаягдлыг бууруулах зохиистой менежментийг төлөвшүүлж, хог							

Хаягдлыг боловсруулж дахин ашиглах, нэмүү шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, байгальд зайлуулах хаягдлын хэмжээг 40 хувь бууруулах	5	Хатуу хог хаягдлыг дахин боловсруулах, сэргээн ашиглахад чиглэсэн хог хаягдал цуглуулах цэгүүдийг бий болгох	2025-2030	БОАЖЯ,	ХЗДХЯ, СаЯ, ГЕГ, холбогдох яамд	УТ	Хог хаягдал цуглуулах стандарт хангасан цэгүүдийг аймаг, нийслэлд бий болгож, дахин боловсруулах хог хаягдлын хэмжээг нэмэгдүүлсэн байна.
Хот, суурин газруудад эрүүл ахуйн шаардлагад нийцсэн хатуу хог хаягдлын цэг талбай байгуулах, түүнийг дахин боловсруулах, эрчим хүч үйлдвэрлэх нөхцөлийг бүрдүүлэх	6	Хот, суурин газруудад эрүүл ахуйн шаардлагад нийцсэн хатуу хог хаягдлын цэг талбай байгуулах, түүнийг дахин боловсруулах, эрчим хүч үйлдвэрлэх нөхцөлийг бүрдүүлэх	2024-2028	АНЗД	БОАЖЯ	ОНТ	Стандартад нийцсэн хог хаягдлын цэгт суурилсан хог хаягдлын дахин боловсруулалт, эрчим хүчний үйлдвэрлэл нэмэгдсэн байна.
<b>ЗОРИЛТ ГУРАВ: Байгаль хамгаалал, ногоон хөгжлийг дэмжих санхүүжилт, зээл, урамшууллын оновчтой хөшүүргийг нэвтрүүлж, байгальд ээлтэй үйл ажиллагаа, цэвэр технологийг дэмжих хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.</b>							
3.1. Дотоодын нийт бүтээгдэхүүний 1-ээс доошгүй хувийг жил бүр байгаль хамгаалал, ногоон хөгжилд зарцуулж, бүтээмжийг дээшлүүлэх, байгалийн нөөц ашиглалтын үр ашгийг нэмэгдүүлэх хөрөнгө оруулалтыг өсгөх	1	Ногоон зээл, ногоон санхүүжилтийн тогтолцоог хөгжүүлэх асуудлыг төрийн мөнгөний бодлогоор дэмжих, бодлогын судалгаа хийж, хэрэгжүүлэх	2024-2028	МБ	САЯ, БОАЖЯ	ОУБ	Ногоон хөгжлийг дэмжих эдийн засгийн хөшүүргийн судалгааны үр дүн гарсан байна.
2	Байгаль хамгаалал, уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийн эсрэг үйл ажиллагаанд улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 1-ээс доошгүй хувийг зарцуулах чиглэлээр эрх зүйн орчныг бүрдүүлэх	Байгаль хамгаалал, уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийн эсрэг үйл ажиллагаанд улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 1-ээс доошгүй хувийг зарцуулах чиглэлээр эрх зүйн орчныг бүрдүүлэх	2024-2028	СаЯ	БОАЖЯ, Ойн газар	УТ	Байгаль хамгааллын тогтвортой санхүүжилт нэмэгдэж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 58 дугаар зарлигийн хэрэгжилт хангагдах нөхцөл бүрдсэн байна.
3	Байгаль хамгааллын тогтвортой санхүүжилтийг бий болгох зорилгоор "Байгаль хамгааллын итгэлцлийн сан"-г байгуулах асуудлыг бодлогоор дэмжиж, "Байгаль хамгааллын байнгын санхүүжилтийн хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх хамтын ажиллагааны гэрээг байгуулан үйл ажиллагааг эхлүүлэх	Байгаль хамгааллын тогтвортой санхүүжилтийг бий болгох зорилгоор "Байгаль хамгааллын итгэлцлийн сан"-г байгуулах асуудлыг бодлогоор дэмжиж, "Байгаль хамгааллын байнгын санхүүжилтийн хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх хамтын ажиллагааны гэрээг байгуулан үйл ажиллагааг эхлүүлэх	2024-2025	БОАЖЯ	ЭЗХЯ, Дэ Нэйче Консерван си байгуулла га	ОУБ	"Байгаль хамгааллын байнгын санхүүжилтийн хөтөлбөр"-ийг баталж, "Байгаль хамгааллын итгэлцлийн сан"-г байгуулсан байна.
4	Монголын ногоон санхүүжилтийн корпорац (МНСК)-ийн үйл ажиллагааг байгаль хамгаалал, уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг зорилт, арга хэмжээтэй уялдуулах	Монголын ногоон санхүүжилтийн корпорац (МНСК)-ийн үйл ажиллагааг байгаль хамгаалал, уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг зорилт, арга хэмжээтэй уялдуулах	2024-2028	"МНСК БСББ" ХХК	Монголын Банкны Холбоо, БОАЖЯ	ХХ	МНСК-ийн үйл ажиллагааны хүрээ өргөжиж, улсын хөгжлийн бодлого, төлөвлөлттэй уялдсан байна.
3.2. Засгийн газрын худалдан авалтын 20-оос доошгүй хувийг байгаль орчинд ээлтэй, үр	1	Засгийн газрын тогтвортой/ногоон худалдан авалтыг хэрэгжүүлэх эрх зүйн орчин, бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний судалгаа хийж, төлөвлөгөө гарган хэрэгжилтийг хангах	2024-2028	СаЯ	БОАЖЯ	ОУБ	Ногоон худалдан авалтын стратеги төлөвлөгөө олон улсын байгууллагын дэмжлэгтэйгээр боловсруулж, хэрэгжүүлж эхэлсэн байна.

	ашигтай, хэмнэлттэй бараа, ажил, үйлчилгээ авахад зарцуулах	2	Зах зээлд нийлүүлж байгаа ногоон бараа, бүтээгдэхүүний судалгааг хийж, бүтээгдэхүүний мэдээллийн сан үүсгэх, мэдээллийг Засгийн газрын хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд ашиглаж хэвшүүлэх	2024-2028	БОАЖЯ	СаЯ ТХААГ, МУХАУТ	ОУБ	Зах зээлийн эрэлт, нийлүүлэлт тэлж, ногоон бараа, бүтээгдэхүүний Засгийн газрын худалдан авалтад эзлэх хувь нэмэгдсэн байна.
		3	Төрийн байгууллагын худалдан авалтыг ногоон худалдан авалтад үе шаттайгаар шилжүүлэх ажлыг эрчимжүүлэх	2024-2028	Бүх шатны ТЭЗ	ТХААГ СаЯ	УТ	Ногоон стандарт, ногоон эдийн засгийн зарчимд үндэслэн төсвийн төлөвлөлтийг хийж хэвшүүлсэн байна
		4	Ногоон худалдан авалтын жишиг баримт бичигт ногоон бүтээгдэхүүний шалгуур үзүүлэлтийг тусгахдаа Үндэсний ногоон таксономиг ашиглаж хэвшүүлэх	2024-2028	СаЯ	ТоС холбоо,		Ногоон худалдан авалтын жишиг баримт бичигт ногоон бүтээгдэхүүний шалгуур үзүүлэлтийг тусгахдаа Үндэсний ногоон таксономиг ашиглаж хэвшүүлэх
3.3.	Банк, санхүүгийн байгууллагын байгаль орчинд ээлтэй тогтвортой санхүүжилтийн тогтолцоог бий болгож, аж ахуйн нэгж, байгууллагын нийгмийн хариуцлагыг өндөржүүлэх	1	Монгол Улсын Тогтвортой санхүүжилт (ТоС)-ийн зарчмуудыг банкны бус санхүүгийн системд үе шаттайгаар нэвтрүүлэх	2024-2028	МБХ СЗХ, ТоС	БОАЖЯ, холбоо, МБ, МББСБХ, МУЦАЭХ МДХ	XX, ОУБ	Тогтвортой санхүүжилтийн тогтолцоо банкны бус санхүүгийн системд нэвтэрч эхэлсэн байна. Аж ахуйн нэгж, байгууллагын нийгмийн хариуцлагыг тогтвортой санхүүжилтийн тогтолцоогоор дамжин өндөржүүлсэн байна.
		2	БОАЖЯ-наас хэрэгжүүлж байгаа ногоон зээлийн хүүгийн хөнгөлөлтийг санхүүжүүлэх арга хэмжээ, ногоон гэрчилгээ олгох ажлын хэрэгжилтэд нөлөөллийн үнэлгээ хийх	2024-2025	БОАЖЯ	ОУБ, Пийл Ин Нийд байгууллага	ОУБ	Ногоон зээл хүүгийн хөнгөлөлтийг санхүүжүүлэх арга хэмжээний үр дүнг тодорхойлж, уг ажлыг эрчимжүүлэх нөхцөл бүрдсэн байна.
		3	Монгол Банкны үйл ажиллагааг байгаль орчин, нийгэмд ээлтэй ногоон хэв загварт шилжүүлэх, чадавхжуулах чиглэлээр гурван жилийн төлөвлөгөө боловсруулан баталж, хэрэгжилтийг хангах	2024-2027	БОАЖЯ	ОУБ	ОУБ	Мөнгөний бодлого зэрэг Монгол Банкны тэргүүлэх үйл ажиллагаагаар дамжуулан тогтвортой/ногоон хөгжлийг дэмжих нөхцөл бүрдсэн байна.
		4	"Байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ), тогтвортой байдлын тайлагнал"-ыг хөрөнгийн биржид бүртгэлтэй аж ахуйн нэгжүүд, үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй аж ахуйн нэгжүүд тайлагнадаг болох ажлыг эрчимжүүлэх	2024-2028	СЗХ, ТоС	МБ, Монголын Хөрөнгийн Бирж, ҮЦАЭБ, ААНБ	XX	Аж ахуйн нэгжийн байгаль орчин, нийгмийн хариуцлага сайжирсан байна.

3.4.	Ногоон хөгжлийн үзүүлэлтийг Үндэсний тооцооны системд тусган, байгаль орчноос эдийн засгийн хөгжилд оруулах хувь нэмрийг тооцох	5	Байгаль орчин, нийгэмд ээлтэй төсөл, үйл ажиллагааг санхүүжүүлэх ногоон бонд гаргахыг бодлогоор дэмжиж, ногоон даатгалын үйл ажиллагааг шат дараатай туршин нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэх	2024-2028	СаЯ	ЭЗХЯ, МБ, СЗХ, БОАЖЯ	ХХ, ОУБ	Засгийн газрын ногоон бондын жишиг баримт боловсруулагдаж, ногоон даатгалын үйл ажиллагаа нэвтрэсэн байна. "Үндэсний тооцооны систем -2025" олон улсын арга зүйн зөвлөмжийг судалж, байгалийн нөөц баалаг, нөөцийн хомсдол, бохирдлын үзүүлэлтүүдийг үндэсний тооцоонд хэрхэн тусгах ажлыг судалсан байна. Эдийн засаг, байгаль орчны хоорондын харилцаа, байгалийн нөөц ашиглалтын үнэлгээ, байгаль орчинд учирсан хохирлыг тодорхойлох боломжтой болсон байна. Үйлдвэрийн эдийн засгийн үр ашгийг тооцох асуудал шийдэгдсэн байна.
1	Байгалийн баялгийн нөөц, түүний ашиглалтын талаарх албан ёсны статистик бүртгэлийн хамрах хүрээг өргөжүүлэх	2024-2028	ҮСХ	БОАЖЯ	ОУБ			
2	Байгаль орчин, эдийн засгийн дансны системийн нэвтрэлтийг эрчимжүүлж, данснуудыг үе шаттайгаар байгуулах	2024-2028	ҮСХ	БОАЖЯ, СаЯ, ТЕГ	УТ, ОУБ			
3	Үйлдвэрийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл, бохирдол, хаягдлын стандарт үзүүлэлтийг тогтоох, түүнийг үнэлэх, татвар ногдуулах байдлаар эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх зохицуулалт, үзүүлэлтийг бий болгох	2024-2028	БОАЖЯ, ХХААХҮЯ	БХБЯ, ЗТХЯ, ЭМЯ, ҮСХ	ОУБ			
4	Ногоон хөгжлийн шалгуур үзүүлэлтийн биелэлтийг хэмжих, тайлагнах, баталгаажуулах системийг нэвтрүүлэх	2024-2028	ТоС холбоо	ҮСХ, БОАЖЯ	ОУБ			Шалгуур үзүүлэлтийг хэмжих, тайлагнах, баталгаажуулах (MRV) систем нэвтрэсэн байна
<b>ЗОРИЛТ ДӨРӨВ: Ногоон ажил эрхлэлтийг дэмжиж, ядуурлыг бууруулан ногоон амьдралын хэв маягийг төлөвшүүлнэ.</b>								
4.1	Төр, хэвшлийн түншлэлийн хүрээнд ажлын нэмэгдүүлж, хөдөлмөрийн насны хүн амын 80-аас дээш хувь нь зохистой хөдөлмөр эрхэлж, баталгаатай орлоготой болох	1	Ногоон ажил эрхлэлтийг дэмжиж, байнгын орлоготой иргэдийн тоог нэмэгдүүлэх ажлыг хэрэгжүүлсэн талаар нэгдсэн мэдээллийг бий болгож, үр дүнг тооцсон байх	2024-2028	ХНХЯ	ҮСХ, БОАЖЯ, УБЕГ	ОУБ	Ногоон ажлын байрны статистик мэдээллийн цахим сан бүрдүүлэх эхлэл тавигдсан байна. Ногоон ажлын байрны шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулсан байна.
2	Зохистой, ногоон ажлын байрны шалгуур үзүүлэлтийг боловсруулж, статистик мэдээлэл бий болгох	2024-2028	ХНХЯ	ҮСХ, БОАЖЯ, УБЕГ	ОУБ			Жилд дунджаар 100-аас доошгүй малчин өрхөд хөнгөлөлттэй зээлийн үйлчилгээ үзүүлж, тоног төхөөрөмж олгох ажлын хүрээнд ногоон үйлдвэрлэл эрхлэх үр чадварыг дээшлүүлсэн байна.
3	Малчид, хөдөөгийн орлого багатай өрхийн ногоон үйлдвэрлэл эрхлэх үр чадварыг дээшлүүлж, хөнгөлөлттэй зээл, тоног төхөөрөмжөөр дэмжих	2024-2028	ХХААХҮЯ, АЗДТГ	ХНХЯ, БОАЖЯ	ОУБ			

4.2.	нөхцөлийг бүрдүүлэх	1	Хүнсний сүлжээнд ногоон хөгжлийн үзэл баримтлалыг нэвтрүүлэх, эрүүл, аюулгүй, тэжээллэг хүнсээр хүн, амыг жигд хүртээмжтэй хангах, импорт орлох хүнсний үйлдвэрлэлийг дэмжих үйл ажиллагааг эрчимжүүлэх	2024-2028	ХХААХҮЯ	БОАЖЯ	УТ, XX	Дотоодын үйлдвэрлэлээр хүн амын хүнсний хэрэгцээ, аюулгүй байдлыг хангах, импортын хүнсний злэх хувийг жил бүр 5-аас доошгүй хувиар бууруулсан байна.
2	Хөдөө аж ахуй салбарт олгогдож байгаа хөнгөлөлттэй зээлийн шалгуурт ногоон технологи нэвтрүүлэх (тухайлбал: мах, арьс шир, ноос ноолуур зэрэг түүхий эд боловсруулах үйлдвэрүүдэд цэвэрлэх байгууламжийн байгальд ээлтэй шийдлийг нэвтрүүлэх) шаардлага тавьж, зээл олголтыг шийдвэрлэх	2024-2028	ХХААХҮЯ	Сая, БОАЖЯ	УТ, XX	Хөдөө аж ахуйн салбарт байгаль орчинд сөрөг нөлөө багатай ногоон үйлдвэрлэлийг хөгжүүлэх үндэс тавигдсан байна.		
4.3.	Байгалийн хүчин зүйл, баялгаас шууд хамаарал бүхий иргэдийн амьжиргааг сайжруулах төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж, уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг даван туулах чадавхыг бэхжүүлэх	1	Байгаль, цаг агаарын давагдашгүй хүчин зүйл, байгалийн гамшгийг хохирол багатай даван туулах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор мал аж ахуй, газар тариалан эрхлэгч нарыг уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох эрсдэл багатай даван туулах сургалтыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах	2024-2028	ХХААХҮЯ	БОАЖЯ, ОБЕГ	УТ	Байгаль, цаг агаарын гамшгийг хохирол багатай даван туулахад иргэд мэдээллээр хангагдаж, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх чадавх эзэмшсэн байна.
2	Цаг агаарын онцгой нөхцөл, байгалийн гамшгийг хохирол багатай даван туулах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор мал аж ахуй, газар тариаланг даатгалын тогтолцоонд бүрэн хамруулах зохицуулалт хийх	2024-2028	ХХААХҮЯ	БОАЖЯ	УТ	Цаг агаарын аюулт үзэгдэл, байгалийн гамшгийг хохирол багатай даван туулах, иргэдийн амьжиргаа эрсдэлд орохгүй байх баталгаа нэмэгдсэн байна.		
3	Ой, байгалийн дагалт баялгийг ашиглах боломжит нөөцийн хүрээнд байгальд ээлтэй технологиор экологийн цэвэр бүтээгдэхүүн бэлтгэж, эко цэвэр, үндэсний "брэнд бүтээгдэхүүн" үйлдвэрлэгч ЖДҮ-ийг хөнгөлөлттэй зээл, санхүүгийн түрээсийн үйлчилгээгээр дэмжих иргэдийн амьжиргааг сайжруулах	2024-2028	ХХААХҮЯ	БОАЖЯ, ХНХЯ, АНЗД	ОУБ, ЖДҮГ	Ой, байгалийн баялгаар "брэнд бүтээгдэхүүн" үйлдвэрлэгч ЖДҮ эрхлэгчийг чадавхжуулж, хөнгөлөлттэй зээл, санхүүгийн түрээсийн үйлчилгээгээр дэмжих зохицуулалтыг бий болгож, иргэдийн амьжиргааг бодлогоор нэмэгдүүлсэн байна.		
4	Байгалийн нөөцийн хамтын менежментийг дэмжиж, "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх, ойн цэвэрлэгээ, цөлжилтөөс сэргийлэх, нөхөн сэргээх үйл ажиллагаанд орон нутгийн иргэдийг татан оролцуулж ажлын байраар хангах	2024-2028	ХНХЯ	БОАЖЯ, АНЗД	ХЭД, С, УТ	Байгаль орчныг хамгаалах, бохирдлыг бууруулах, нөхөн сэргээх, эрүүл аюулгүй эко орчныг бүрдүүлэхэд чиглэсэн хөтөлбөрт жилд дунджаар 15 мянгаас доошгүй хүнийг хамруулсан байна.		

	5	Малчид, тариаланчдын эрхэлж буй хүнсний ногооны тариалалтыг дэмжиж бүтээгдэхүүний хадгалах агуулахыг бий болгох, зах зээлд бүтээгдэхүүнийг зах зээлийн эргэлтэд оруулах	2024-2028	БОАЖЯ	ХХААХУЯ, ОУБ	ОУБ	Байгалийн эдийн засгийн үнэ, үр өгөөжийг тогтоох систем бүрдэж, мал аж ахуй эрхлэлтээс үүсэх байгальд учруулах нөлөөллийн талаарх мэдээлэл бүрдсэн байна.	
<b>ЗОРИЛТ ТАВ: Байгальд зохицсон ахуй, соёлын үнэт зүйлсийг хөгжүүлж, боловсрол, шинжлэх ухаан, технологи, инновацыг ногоон хөгжлийн хурдасгуур болгоно.</b>								
5.1.	Тогтвортой хөгжлийн боловсролоор дамжуулан эх оронч байгаль орчноо хамгаалах уламжлалт заншил, байгальд ээлтэй амьдралын хэв маяг, нөөцийн хэмнэлттэй, үр ашигтай хэрэглээний соёлыг төлөвшүүлэх	1	Тогтвортой хөгжлийн үзэл санаагаар бүх шатны сургалтын хөтөлбөрийг баяжуулж, эко сургуулиудад түшиглэн сургалтын орчин бүрдүүлж, багш, ажилчдыг чадавхжуулах	2024-2028	БШУЯ	БОАЖЯ	УТ, ОУБ	Бүх шатны сургалтын хөтөлбөрт тогтвортой хөгжлийн үзэл санааг тусгаж, хүүхдүүд ногоон хөгжлийг дэлгэрүүлэгч болж төлөвшсөн байна.
		2	Тогтвортой хөгжил, ногоон хөгжлийн үзэл санаа, орчин үеийн амьдралын хэмнэлд нийцсэн хэмнэлттэй, үр ашигтай хэрэглээний соёлыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах ажлыг байнгын давтамжтай явуулах төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх	2024-2026	БОАЖЯ	МҮОНРТ, бусад мэдээллийн байгууллагууд	ОУБ	Тогтвортой хөгжил, ногоон хөгжлийн талаарх мэдлэгийг олон нийтэд ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар хүргэсэн байна.
		3	Ногоон хөгжил, ногоон эдийн засгийн мэдлэг олгох зорилтот бүлгүүд рүү чиглэсэн сургалтын цахим системийг хөгжүүлэх, гарааны компанийг бизнес инкубаторт бойжуулахад дэмжлэг үзүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх	2024-2028	БОАЖЯ	МУХАУТ	ОУБ	Сургалтын модуль, цахим систем гарсан байна.
		4	10000 залуусыг биенесийн сургалтад хамруулах, 100 суралцагчид гарааны бизнес эхлүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх хөтөлбөрийн хүрээнд ногоон биенес нэвтрүүлэх, хөгжүүлэх чиглэлийн сургалтыг зохион байгуулах	2024-2028	МУХАУТ	БОАЖЯ	УТ, ОУБ	Сургалтын модуль, цахим систем гарсан байна.
5.2.	Байгаль орчны удирдлагын MNS ISO14000 багц аж ахуйн нэгж, байгууллагад нэвтрүүлэхийг дэмжих	1	Байгаль орчны удирдлагын ISO 14001, 14051 стандартыг сурталчлан таниулах болон аж ахуйн нэгж, байгууллагад нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх	2024-2028	БОАЖЯ	СХЗГ, МУХАУТ	ОУБ, ХХ	Сургалт, сурталчилгааны хөтөлбөр, сургалтын модуль боловсруулж, мэргэжилтэн сургасан байна.
		2	Шинэ техник технологийг өөрийн орны нөхцөлд үр дүнтэй ашиглах, тэргүүлэгч техник технологийг харилцах хүний нөөцийг системтэйгээр бэлтгэх	2024-2028	БШУЯ	ЭШБ, ХХ	УТ, ХХ	Шинэ техник, технологийг ойлгож, хурдтай шилжүүлэх чадварлаг хүний нөөцтэй болсон байна.
5.3.	Цэвэр технологи, инновацыг хөгжүүлж, ногоон хөгжлийн хурдасгуур болгох	1	Залуу эрдэмтэн судлаачдын дунд ногоон хөгжил, ногоон технологийн чиглэлээр төсөл шалгаруулж, санхүүжүүлэх	2024-2028	БОАЖЯ	ШУА	ОУБ	Залуу судлаачдад грант олгож, гэрээ байгуулсан байна.
		2	Шинэ техник технологийг өөрийн орны нөхцөлд үр дүнтэй ашиглах, тэргүүлэгч техник технологийг харилцах хүний нөөцийг системтэйгээр бэлтгэх	2024-2028	БШУЯ	ЭШБ, ХХ	УТ, ХХ	Шинэ техник, технологийг ойлгож, хурдтай шилжүүлэх чадварлаг хүний нөөцтэй болсон байна.

ЗОРИЛТ ЗУРГАА: Уур амьсгалын өөрчлөлт, бүс нутгийн байгалийн нөөц баялаг, сэргэх чадавхад нийцүүлэн хүн амын суурьшлыг төлөвлөн хөгжүүлнэ.									
6.1	"Ногоон" хот, тосгоныг хөгжүүлж, орон нутагт тав тухтай ажиллаж, амьдрах орчин, нөхцөлийг бүрдүүлэх	1	Хот суурины хөгжлийн төлөвлөгөөг "Ногоон хот"-ын зарчимд нийцүүлэн боловсруулж, хэрэгжүүлэх	2024-2028	БОАЖЯ	БХБЯ АНЗД	ОУБ	Ногоон хотын үзэл санаа бүхий суурин газрууд нэмэгдсэн байна.	
		2	Уул уурхайн үйлдвэрлэлийг түшиглэсэн хот суурины хөгжлийн төлөвлөлтийг байгаль орчинд ээлтэй, ногоон үзэл баримтлалд нийцүүлэн боловсруулах	2024-2028	БХБЯ	УУХҮЯ, БОАЖЯ, АНЗД	ХХ, УТ	Жишиг ногоон хот суурины төлөвлөлтийг бий болгосон байна.	
	6.2.	Хот, тосгоны газар ашиглалт, барилгажилтын бүсчлэл, дэд бүтцийн төлөвлөлтийг боловсронгуй болгон хэрэгжүүлэх, хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалтыг бий болгож агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулах	2	Улаанбаатар хотын гэр хорооллын ариун цэврийн байгууламжийг боловсронгуй болгох жишиг төсөл хэрэгжүүлж, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх	2024-2028	БОАЖЯ	НЗД	ОУБ, ХХ	Манай орны нөхцөлд тохирсон өрхийн ариун цэврийн байгууламжийн шийдлийг олж, туршин нэвтрүүлсэн байна. Эхний ээлжид 8000 өрх хамрагдсан байна.
6.3.	Ус хангамж, ариутгах татуургын байгууламжийн хүчин чадал, бүтээмжийг нэмэгдүүлж, хүн амын 90-ээс доошгүй хувийг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн үндныг усаар хангаж, сайжруулсан ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг 60-аас доошгүй хувьд хүргэх	1	Ус хангамж, ариутгах татуургын байгууламжийн стандарт, зураг төсөл, технологийн шийдлийг ногоон хөгжлийн шаардлагад нийцүүлэн шинэчлэх ажлыг зохион байгуулах	2024-2028	БХБЯ	БОАЖЯ, СХЗГ	УТ, ОНТ	Ус хангамж, ариутгах татуургын байгууламжийн стандарт, зураг төсөл, технологийн шийдэл ногоон шаардлагад нийцсэн байна.	
		2	Хот, суурины төлөвлөлт, дахин төлөвлөлтөд ус хангамж, ариутгах татуургын бие даасан, усны хэмнэлттэй, "саарал ус" ашиглах ухаалаг, цогц шийдлийг төлөвлөж, хэрэгжүүлэх	2024-2028	БХБЯ	СаЯ, БОАЖЯ, АНЗД	ОНТ, ХХ	Ус хангамж, ариутгах дэвшилтэт техник, технологийг төлөвлөж нэвтрүүлсэн байна.	
	3	Хот, суурин газрын ахуйн хаягдал усыг стандартын түвшинд хүртэл цэвэрлэж, үйлдвэрлэлд дахин ашиглах боломжийг бүрдүүлэх	2024-2028	БХБЯ, АНЗД, ХХААХҮЯ, БОАЖЯ	ЭХЯ, СаЯ, ЭЗХЯ	ХХ, ОУБ	Цэвэрлэх байгууламжаас гарах цэвэрлэсэн ус, лагийн дахин ашиглалт нэмэгдсэн байна.		

6.4.	Улаанбаатар хот болон бусад хот, сууриныг дахин төлөвлөж, эдэлбэр газарт ногоон байгууламжийн эзлэх хувь хэмжээг 30 хувьд хүргэх	1	Хот, суурины ногоон байгууламжийн тухай хуулийн үзэл баримтлал, хуулийн төслийг боловсруулах	2024-2028	БХБЯ	БОАЖЯ, СХЗГ	УТ	Хот, суурины ногоон байгууламжийг төлөвлөх, байгуулах, ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх эрх зүйн орчин бүрдсэн байна.
		2	"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний стратеги төлөвлөгөөтэй уялдуулан Улаанбаатар хотын ногоон байгууламжийн мастер төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэн 1 хүнд ноогдох ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх	2024-2028	НЗД	БОАЖЯ, БХБЯ	ОНТ	Цэцэрлэгжүүлэлт батлагдсан тодорхой төлөвлөгөөний дагуу хийгдэнэ. УБ хотод 2100 га талбай бүхий томоохон цэцэрлэгүүд байгуулагдаж, 150-аас доошгүй га талбайг цэцэрлэгжүүлсэн байна.
		3	Хот хоорондын автозамын дагууд зорчигчийн ая тухыг хангасан, ногоон шийдэлтэй үйлчилгээний цогцолбор бүхий түр буудаллах цэгийг хувийн хэвшил, нутгийн иргэдийн оролцоотойгоор төлөвлөж байгуулах	2024-2028	ЗТХЯ	БОАЖЯ Бүх шатны ЗД	ОНТ, ХХ	Зорчигчийн ая тухыг хангасан авто зогсоолтой болж, орчны бохирдол буурч, орон нутгийн иргэд байнгын ажлын байртай болсон байна.
6.5.	Явган хүн зорчих хэсэг, ногоон байгууламж, дугуйн зам, зогсоолын төлөвлөлт, зохион байгуулалтыг боловсронгуй болгож, иргэд явган явах, дугуйгаар зорчих орон зайг нэмэгдүүлэх	1	Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрмийг ногоон хотын төлөвлөлтийн шаардлагад нийцүүлэн шинэчлэн боловсруулах	2024-2028	БХБЯ	БОАЖЯ, НЗД	УТ, ОНТ	Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм шинэчлэн боловсруулагдсан байна.
		2	Туул, Сэлбэ голын эргийн дагууд сэргээн сайжруулах төсөл хэрэгжүүлж иргэд амарч зугаалах, спортоор хичээллэх ая тухтай орчин бүрдүүлэх	2024-2028	НЗД	БОАЖЯ	ОУБ, ОНТ	Баянзүрхийн гүүрнээс Сонголонгийн гүүр хүртэл 21 км урт дугуйн зам, бусад байгууламжтай болсон байна.

АЗД – Аймгийн засаг дарга  
 АНЗД – Аймаг, Нийслэлийн засаг дарга  
 БХБЯ – Барилга, хот байгуулалтын яам  
 БХС – Байгаль хамгаалах сан  
 БШУЯ – Боловсрол, шинжлэх ухааны яам  
 ГЗБГЗЗЭГ – Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар  
 ГХЯ – Гадаад харилцааны яам  
 ЖДҮГ – Жижиг дунд үйлдвэрийн газар  
 ЗД – Засаг дарга

ЗТХЯ – Зам, тээврийн хөгжлийн яам  
МБ – Монгол банк  
МБХ – Монголын банкны холбоо  
МДХ - Монголын даатгуулагчдын холбоо  
МҮОНРТ – Монголын үндэсний олон нийтийн радио телевиз  
МҮХАҮТ – Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим  
МББСБХ - Монголын Банк Бус Санхүүгийн Байгууллагуудын Холбоо  
МҮЦАЭХ - Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо  
НБОГ – Нийслэлийн байгаль орчны газар  
НЗД – Нийслэлийн засаг дарга  
НЭМҮТ – Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв  
ОНТ – Орон нутгийн төсөв  
ОУБ – Олон улсын байгууллага  
СЗХ – Санхүүгийн зохицуулах хороо  
СХЗГ – Стандарт, хэмжил зүйн газар  
СаЯ – Сангийн яам  
ТББ – Төрийн бус байгууллага  
ТЕГ – Татварын ерөнхий газар  
ТЕЗ – Төсвийн ерөнхийлөн захирагч  
ТоС холбоо – Тогтвортой санхүүгийн холбоо  
ТХААГ – Төрийн худалдан авах ажиллагааны газар  
УБЕГ – Улсын бүртгэлийн ерөнхий газар  
УТ – Улсын төсөв  
УУХҮЯ – Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам  
ҮСХ – Үндэсний статистикийн хороо  
ҮЦАЭБ – Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагууд  
ХНХЯ – Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам  
ХХ – Хувийн хэвшил  
ХХААХҮЯ – Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам  
ХХЕГ – Хил хамгаалах ерөнхий газар  
ХЭДС – Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан

ЦУОШГ – Цаг уур, орчны шинжилгээний газар  
ЦХХХЯ – Цахим хөгжил, харилцаа холбооны яам  
ШУА – Шинжлэх ухааны академи  
ЭЗХЯ – Эдийн засаг, хөгжлийн яам  
ЭМЯ – Эрүүл мэндийн яам  
ЭШБ – Эрдэм шинжилгээний байгууллагууд  
ЭХЗ – Эрчим хүчний зөвлөх  
ЭХЯ – Эрчим хүчний яам